

Шинэ Коронавирус (COVID-19) хариу арга ХЭМЖЭЭ

~Жирэмсэн ЭМЭГТЭЙЧҮҮДЭД зориулав~



Жирэмслэлтэд үзүүлэх халдварын нөлөө

Одоогоор жирэмсний сүүлийн 3 сард халдварласан өвчний явц Хүндрэл нь жирэмсэн биш эмэгтэйнхтэй ижил байна. Гадаадын судлаачид урагт эхээс халдвар дамжиж буйг мэдээлж буй боловч ургийн гажиг, амьгүй төрөлт, зулбалтын ямар нэг тохиолдол илрээгүй байгаа тул жирэмсэн эмэгтэй та хэт ихээр санаа зовинох шаардлагагүй.

Урьдчилан сэргийлэлт

Ерөнхийдөө, жирэмсэн эмэгтэйд уушигны хатгалгаа илүү хүндрэх эрсдэлтэй байдаг.

Гараа байнга угааж, олон хүн цугласан газар очихоос зайлсхийн, өөрийн эрүүл мэнддээ анхаарал тавиарай.

Дараах “Гурван Х”-с зайлсхийх нь зүйтэй.

1. Хаалттай орчин
2. Хүн цугласан газар
- 3 Хэт ойрын харилцаа

Хөдөлмөр эрхлэлт

Ажлаа хийж байгаа эмэгтэйчүүд ажил олгогчтойгоо ажилдаа ирэх буцах цагаа зохицуулах, гэрээсээ ажлаа хийх талаар зөвшилцөөрэй

Эрүүл мэнд, Хөдөлмөр, Халамжийн Яам жирэмсэн эмэгтэйчүүдийн сэтгэлзүйн болон эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангахаар ажиллаж байна.

Жирэмсэн эмэгтэйд зориулсан стандарт урьдчилан сэргийлэлт, жирэмсний хяналт, халууралтын үеийн заавар зөвлөгөө арын хуудсанд бий. Коронавирусын тухай ерөнхий болон нарийвчилсан мэдээллүүдийг Эрүүл Мэнд, Хөдөлмөр, Халамжийн Яамны болон бусад академик нийгэмлэгүүдийн вэб хуудаснаас авах боломжтой.

Эрүүл Мэнд, Хөдөлмөр, Халамжийн Яам <Шинэ Коронавирус Асуулт & Хариулт>

https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/kenkou_iryuu/dengue_fever_qa_00014.html

Японы Эх Барих Эмэгтэйчүүдийн Халдварт Өвчнүүдийн Нийгэмлэг (JSIDOG) <Жирэмсэн/Жирэмслэхээр төлөвлөх буй эмэгтэйчүүдэд зориулсан Шинэ Коронавирус (COVID-19)-н

мэдээлэл (нөгцөл байдлаас хамаарч шинэчлэгддэг)> <http://jsidog.kenkyukai.jp/information/> (зөвхөн япон хэл дээр)

Энэ товхимол одоогоор мэдэгдэж буй мэдээллүүдийг ашиглан хийгдсэн ба нөгцөл байдал өөрчлөгдөхийн хирээр шинэчлэгдэх боломжтой анхаараарай.



◆ Зөвлөгөө өгөх, оношлох шинэ шалгуур

- Харьцангуй хөнгөн хэлбэрийн ханиадны шинж тэмдэг бүхий (халуурах, ханиах зэрэг) жирэмсэн эмэгтэйчүүд COVID-19 тодорхой мэдээлэл бүхий зөвлөгөө өгөх төвүүдэд даруйхан утсаар хандах шаардлагатай
- Та эмнэлэгийн байгууллагаар үйлчлүүлэхдээ амны хаалтаа зүүж, гараа угаан ханиаж найтаах үедээ ам хамраа нусны алчуураар эсвэл ханцуйгаараа хааж байгаарай.
<https://www.mhlw.go.jp/content/000628620.pdf>



◆ Жирэмсэн эмэгтэйд зориулсан мужийн зөвлөгөө өгөх төвүүд

- Жирэмсэн эмэгтэйд зориулсан зөвлөгөө өгөх төвүүд бүх муж, хот, дүүрэгт байдаг.
https://www.mhlw.go.jp/stf/newpage_11296.html (зөвхөн Япон хэл дээр)
※ COVID-19-н талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг бусад улсын хэл дээр SHARE-н вэб хуудаснаас үзэх боломжтой
https://share.or.jp/english/news/covid-19_information_for_foreigners_b#multi



◆ Төрөлт

- COVID-19-р халдварласан жирэмсэн эмэгтэйн тайван, эсэн мэнд амаржих орчинг бүрдүүлэх бэлтгэл хангахаар муж бүр одоогоор ажиллаж байна. Хэрэв та халдвар авсан бол эмчтэйгээ төрөлт, тээлтийн тухай зөвлөлдөөрэй.

◆ Жирэмсэн эсвэл нярай хүүхэдтэй ч ажил эрхэлж буй эмэгтэйчүүдэд

- Жирэмсэн ажилчин эмчийн зөвлөсөний дагуу COVID-19 халдварын үлмаас өөрийн болон тээж буй хүүхдийн биеийн ба сэтгэцийн эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой ямар нэг хүсэлт гаргасан тохиолдолд ажил олгогч эмэгтэйд эмчийн зөвлөсөний дагуу шаардлагатай арга хэмжээг (ажлын цаг, ажлын ачааллыг зохицуулах) авч өгөх хэрэгтэй.
(Act on Securing, Etc., of Equal Opportunity and Treatment between Men and Women in Employment)

※ Энэ арга хэмжээг 2020 оны 5 сарын 7-с 2021 оны 1 сарын 31 мөрдөнө

- Жирэмсэн эсвэл нярай хүүхэдтэй эмэгтэй эмчийн зааваргүй байсан ч амралтын өдрүүдээр, илүү цагаар мөн шөнийн ээлжинд ажиллахгүй байх хүсэлт гаргах эрхтэй. (Labour standard Act)
---- Ажил эрхэлж буй жирэмсэн эмэгтэйд хамгаалах үхүүлэх хуудсыг дараах вэбсайтаас үзээрэй---- <https://www.mhlw.go.jp/content/11909000/000628247.pdf>



- Эрүүл мэнд, Хөдөлмөр, Халамжийн Яам үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудтай шинэ коронавирустай холбоотойгоор жирэмсэн эмэгтэй ажлаасаа санаа зовох зүйлгүйгээр чөлөө авах зэрэг тал дээр хамтран ажиллах хүсэлтээ хүргүүлээд байна.
https://www.mhlw.go.jp/stf/newpage_11067.html



◆ Мэргэжилтнүүдийн илгээсэн видео мессежүүд

- Эмнэлгийн мэргэжилтнүүдийн жирэмсэн болон бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүдэд зориулсан видео мессежүүд
https://www.mhlw.go.jp/stf/newpage_10996.html (YouTube суваг дээр автомат орчуулагчийн тусламжтайгаар үзэх боломжтой)

